

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2021 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН МЭДЭЭ

НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР:

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаан 1 удаа хуралдаж, тус аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай, аймгийн Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийн бүрэлдэхүүн шинэчлэн батлах тухай, шуурхай багийн бүрэлдэхүүн, ажиллах чиг үүргийг шинэчлэн батлах тухай, олон нийтийн “Алтай” радиогийн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн шинэчлэн батлах тухай, “Сутай хайрхан” уулын менежментийн төлөвлөгөө батлах тухай, нийт 5 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн хурал 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр хуралдаж, аймгийн ГХУСАЗС зөвлөлийн 2020 оны үйл ажиллагааны хэрэгжилт болон тус салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан тухай танилцуулан, 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталлаа.

Мөн аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу аймгийн ИТХ-ын дарга Д.Даваадоржоор ахлуулсан ажлын хэсэг Гуулин, Дэлгэр, Чандмань, Эрдэнэ, Цогт, Баянтоорой, Бигэр сумдад ажиллаж, заавар зөвлөгөө, чиглэл өглөө.

Сумдын Засаг дарга нарын аймгийн Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээний биелэлтийг дүгнэж, ХШҮДАХ-т хүргүүлээ.

Сумдын төрийн байгууллагуудын үйл ажиллагаа, ажлын зохион байгуулалт, өвөлжилт, КОВИД-19 өвчнөөс урьдчилан сэргийлэх бэлэн байдал, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан төсөл, арга хэмжээг танилцуулах зорилгоор 3 чиглэлд ажлын хэсэг гарч, 01 дүгээр сарын 11-ний өдрөөс 14-ний өдрүүдэд бүх сумдад ажиллалаа. Сумдад ажиллахдаа иргэд, хөдөлмөрчдөөс гарсан санал, хүсэлтийг нэгтгэж, холбогдох агентлаг, байгууллагуудад хүргүүлэн тэдний санал, хүсэлтийг үйл ажиллагаандаа тусган хэрэгжилтийг ханган ажиллаж, тулгамдаж буй асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн талаарх биелэлтийг ирүүлэх хугацаатай үүрэг, чиглэл, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, үр дүнг дээшлүүлэхэд чиглэсэн санал, зөвлөмжөөр ханган ажиллалаа.

2020 оны мал тооллогын урьдчилсан дүнгээр 3310.8 мянган мал тоологдож, нийт малын тоо өмнөх оноос 286.9 мянга буюу 7.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Нийт 7915 малчин өрхийн 13128 малчны 35.4 хувь нь зээлтэй, 36.8 хувь нь нийгмийн даатгалд хамрагдсан байна. Малчдын 0.1 хувийг 16 хүртэл насны хүүхэд, 28.0 хувийг 16-34 насныхан, 59.1 хувийг 35-59 насныхан, 12.8 хувийг 55-аас дээш насны малчид байна. Нийт малчдын 57.6 хувь нь эрэгтэй, 42.4 хувь нь эмэгтэйчүүд эзлэж байна.

Улаанбаатар хот дахь Говь-Алтай аймгийн нутгийн зөвлөлөөс өвөлжилт хүндэрсэн сумдад “Малчдад хүргэх тусламж”-ийг илгээснийг малчдад хуваарилан хүргэлээ.

НҮБ-ын ХХААБ, ХХААХҮЯ-тай хамтран “Зорилтот бүлгийн малчин өрхийн амьжиргааг зудын эрсдэлээс хамгаалахад дэмжлэг үзүүлэх” техник туслалцааны төсөл тус аймагт хэрэгжиж байгаатай холбогдуулан ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, НҮБ-ын ХХААБ-ын суурин төлөөлөгч Винод Ахужа тэргүүтэй ажлын хэсэг аймгийн удирдлагуудтай уулзаж, хөдөө аж ахуйн салбарын өнөөгийн байдалтай танилцлаа. Уг төсөлд Бигэр, Бугат, Дэлгэр, Тонхил, Төгрөг, Цээл, Халиун, Чандмань сумдын 300 ба түүнээс цөөн тооны малтай, хөдөлмөрийн насны, өрх толгойлсон, олон хүүхэдтэй, хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүнтэй, мал аж ахуйгаас өөр амьжиргааны эх үүсвэргүй, отор нүүдэл хийх бүл, чадал муутай зорилтот бүлгийн малчид хамрагдаж байгаа юм. Мөн ажлын хэсгийн бүрэлдэхүүн Дэлгэр сумд ажиллаж, тус сумаас сонгогдсон зорилтот бүлгийн 4 малчин өрхөд тусламжийн багцыг хүлээлгэн өглөө.

АНУ-ын Олон улсын хамтын ажиллагааны газар, Дэлхийн зөн Монгол олон улсын байгууллагаас хамтран хэрэгжүүлж байгаа “Гамшигт тэсвэртэй орон нутаг” төслийн нээлтийн цахим хурал 01 дүгээр сарын 12, 13-ны өдрүүдэд зохион байгуулагдлаа. Тус хуралд төсөл хэрэгжих Улаанбаатар, Эрдэнэт хотууд болон Дорнод, Орхон Дорноговь, Дундговь, Увс, Говь-Алтай аймгуудын төлөөлөл оролцож, төслийн 2021-2022 оны төлөвлөгөөнд санал хүргүүллээ.

Гадаад харилцаа, хамтын ажиллагаа, төсөл хөтөлбөрийн 2020 оны тайланг Гадаад харилцааны яамны Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүллээ.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2020 оны биелэлтийг нэгтгэн аймгийн Засаг даргын зөвлөлийн 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэн, холбогдох шийдвэр гаргуулан, 81.3 хувийн хэрэгжилттэйгээр Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн систем /unelgee.gov.mn/-д заалт бүрээр байршууллаа.

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2020 оны хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээний дүнг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хүргүүллээ.

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтэд тус тус хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг боловсрууллаа.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны тогтоолын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хүргүүллээ.

Засгийн газрын 2020 оны 206, 216, 217, 218 тогтоолоор шинэчлэн баталсан журмууд болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар баталсан аргачлал, загварыг танилцуулах цахим сургалтад хэлтэс, агентлагийн 40 албан хаагчийг оролцож, мэдлэг чадвараа дээшлүүллээ.

Үйлчилгээний нэгдсэн төв нь 162 нэр төрлийн үйлчилгээг үзүүлж байгаа бөгөөд тайлант хугацаанд 1600 иргэн үйлчилгээ авлаа.

Тус төвөөр үйлчилгээ авсан 720 иргэнд холбогдох зөвлөгөө мэдээллийг өглөө.

Тайлант хугацаанд 8 өргөдөл ирснээс 5 өргөдлийг шийдвэрлэж, 3 өргөдлийн хугацаа болоогүй судлагдаж байна. Шийдвэрлэлт нь 62.5 хувьтай байна.

“Иргэдээ сонсох нээлттэй утас 7048-1111” дугаарын утсанд 13 дуудлага хүлээн авснаас, хувийн мэдээллээ бүрэн өгч “E-Office” программд бүртгэгдсэн 11 санал, хүсэлтийг холбогдох байгууллагуудад шилжүүлэн шийдвэрлүүлээ. Хугацаа болоогүй судлагдаж байгаа 4 өргөдөл байна. Шийдвэрлэлт 69.2 хувьтай байна.

Төрийн үйлчилгээний нэгдсэн системээс иргэн, эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай, шүүхийн шийдвэрээр бусдад төлбөргүй эсэх, төрсний бүртгэлийн, иргэний үнэмлэхний, гэрлэлт бүртгэлийн, үл хөдлөх хөрөнгийн, жолоочийн лавлагаа зэрэг нийт 108 лавлагааг олгож төсөвт 110.5 мянган төгрөгийг төвлөрүүллээ. Мөн сумдын цахим системийн судалгааг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын ажилтан Khishigjargal@cita.gov.mn цахим хаягаар хүргүүллээ.

ХОЁР. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Аймгийн Засаг дарга бүрэн эрхийнхээ хүрээнд тайлант хугацаанд 36 захирамж гаргасан бөгөөд 2020 оны аймгийн Засаг даргын захирамж, албан даалгавар, “Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх” дэд хөтөлбөр, “Архигүй-Алтайчууд” дэд хөтөлбөр, “Авлигын эсрэг” дэд хөтөлбөрүүдийн биелэлтийг жилийн эцсийн байдлаар тус тус нэгтгэж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэлээ.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсийн тайланг Хууль зүй дотоод хэргийн яаманд, Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал болон үндэсний аюулгүй байдлыг хангах чиглэлээр 2020 онд хийсэн ажлын тайланг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн даргад, Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний стратеги хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг Зам тээвэр хөгжлийн яаманд, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн биелэлтийг Авлигатай тэмцэх газрын урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх хэлтэст тус тус хүргүүллээ.

Мөн 2 хүний албан тушаалд томилогдохоор мэдүүлсэн урьдчилсан мэдүүлгийг цахим системд бүртгэж, 2020 оны хөрөнгө орлогын мэдүүлэг гаргагч албан тушаалтнуудын нэрсийн жагсаалтыг гарган Авлигатай тэмцэх газарт тус тус хүргүүлж, ХАСХОМ мэдүүлэг гаргах ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулж нийт 150 албан тушаалтны мэдүүлгийг шинэчилж мэдүүллээ.

Архивын тасагтай хамтран Бигэр, Бугат, Дарив, Эрдэнэ, Шарга, Тайшир, Цогт, Төгрөг, Есөнбулаг, Жаргалан, Цээл сумдын Засаг даргын эрх хэмжээнийхээ хүрээнд гаргасан нийт 178 захирамжийн эрх зүйн үндэслэл, Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар, баримт бичгийн стандарт хангасан эсэхийг хянаж, 48 захирамжид хууль тогтоомж, стандартын шаардлага хангах талаар зөвлөмж хүргүүллээ.

Нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний актын төсөл боловсруулах, төсөлд санал авах, нөлөөллийн шинжилгээ хийх, батлуулах, хянуулж бүртгүүлэхээр хүргүүлэхэд анхаарах асуудлын талаар 12 заалт бүхий зөвлөмж боловсруулан сумдын Засаг дарга, агентлагийн дарга нарт хүргүүлж, мэргэжил арга зүйгээр ханган ажиллалаа.

Шинэ Үндсэн хууль батлагдсаны 29 жилийн ойн өдрийг тохиолдуулан агентлаг, сумдын Засаг даргын Тамгын газарт шинэ Үндсэн хуульд орсон нэмэлт өөрчлөлтийн талаар мэдээллийг бэлтгэн хүргүүлж, байгууллагын цахим хуудаст байршуулж ажиллалаа.

Аймгийн Засаг дарга, Дэлхийн зөн ОУБ-ын Төлөөлөгчийн газартай байгуулах хамтран ажиллах, ус хангамж, ариун цэврийн байгууламжийн үйлчилгээг сайжруулах талаар хамтран ажиллах, инженер геологийн судалгааны ажил гүйцэтгэх гэрээнүүдийг хянаж, санал хүргүүллээ.

Архивын тасаг: Архивын баримтаас иргэдийн хүсэлтийн дагуу 130 иргэнд мал тооллого, цалингийн лавлагаа болон тушаалын хуулбар нийт 1800 хуудас бүхий лавлагаа олгож, 1768.0 мянган төгрөгийн хураамжийг төрийн сангийн дансанд төвлөрүүллээ.

Архивын тасгийн 2020 оны үйл ажиллагааны тайлан, статистик мэдээ, хяналт шалгалтын ажлын тайлан гаргаж Архивын ерөнхий газарт хүргүүллээ.

Аймгийн Прокурорын газар, Иргэний хэргийн анхан шатны шүүх хамтран зохион байгуулсан Зөрчлийн тухай хуулийг хэрэгжүүлэх уулзалтад оролцсон бөгөөд архив, албан хэрэг хөтлөлтийн хяналтын улсын байцаагчийн 2021 оны хяналт шалгалтын төлөвлөгөөг боловсруулж, зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий ажилтны судалгааг гарган аймгийн Прокурорын газарт хүргүүлж, Чандмань сумын Үүрийн туяа нэгдлийн 38 хадгаламжийн нэгжид иж бүрэн шалгалт хийлээ.

Есөнбулаг сумын 1 дүгээр цэцэрлэгийн архивын бүртгэл, хадгалах хугацаа дууссан устгах баримт бичиг, Прокурорын газрын байнга хадгалах баримтын данс, түр хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэлийг хянаж, заавар зөвлөгөө өглөө.

Сумдын Засаг даргын Тамгын газарт 2018-2020 мал тооллогын бүртгэлийн баримтыг төрийн архивын сан хөмрөгт цахим хэлбэрт шилжүүлж хамтран ажиллах талаар албан бичгийг хүргүүллээ. Тус ажлын хүрээнд Шарга, Баян-Уул, Дарив, Жаргалан сумын мал тооллогын 30 хадгаламжийн нэгжийн 6256 хуудас баримтыг засварлаж, Дарив сумын мал тооллогын 9 хадгаламжийн нэгжийн 4370 хүний нэрийг шивж, 2011 оны мал тооллогын баримтыг цахим хэлбэрт, Тайшир сумын 9 хадгаламжийн нэгжийн 2701 хуудас баримтыг PDF, JPEG хэлбэрт шилжүүлж, 110 хөмрөг үүсгэгч байгууллагын архивын баримтын тоо хэмжээ, хадгалалтын мэдээг www.burtgel.archives.gov.mn прораммд бүртгэж орууллаа.

Цагдаагийн газар: Аймгийн хэмжээнд 01 сарын байдлаар нийт 22 гэмт хэрэг гарснаас хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг 8, хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг 1, өмчлөх эрхийн эсрэг 6, олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг 5, хүрээлэн байгаа орчны эсрэг 1, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг 1 хэрэг гарч, дээрх

хэргүүдтэй холбоотойгоор 17.2 сая төгрөгийн хохирол учирч, 3.5 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлээд байна. Хохирол нөхөн төлүүлэлт 20.3 хувьтай байна.

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудаас нийт 107 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 47, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 60 ирсэн байна. Үүнээс гэмт хэргийн шинжтэй 12 гомдол, мэдээлэлд хэрэг бүртгэлийн хэрэг нээж, 15 гомдол, мэдээлэлд хэрэг бүртгэлийн хэрэг нээхээс татгалзаж, зөрчлийн шинжтэй 36 гомдол мэдээллийг зөрчлийн хэрэг нээх болон хялбаршуулсан журмаар шийдвэрлэж, 9 гомдол мэдээлэлд зөрчлийн хэрэг нээхээс татгалзсан.

Зөрчлийн арга хэмжээ авагдсан 649 зөрчлөөс 627 хүн, хуулийн этгээдийг 18361.0 мянган төгрөгөөр торгож, 4 хүн баривчлагдсан, 26 хүн эрүүлжүүлэгдэн, 11 хүний эрх хасагдсан байна.

Улсын бүртгэлийн хэлтэс: Иргэний бүртгэл, хуулийн этгээдийн бүртгэлийн үйл ажиллагааг хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд явуулж, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад түргэн шуурхай чирэгдэлгүй үйлчилж ажиллалаа.

Тус сард иргэний бүртгэлийн 319 лавлагааг өгч, 7 иргэний гадаад паспортын захиалга авч, 7 хуулийн этгээдийг шинээр, 17 хуулийн этгээдийг дахин бүртгэн гэрчилгээ олгож, бүртгэлийн цахим мэдээллийн санг тухай бүр баяжуулсан.

Иргэд, хуулийн этгээдийн эд хөрөнгө өмчлөх эрх болон түүнтэй холбоотой бусад эрхийн 335 мэдүүлгийг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэн, иргэд хуулийн этгээдээс бүртгэлийн үйлчилгээний хураамж 2219.2 мянган төгрөг, улсын тэмдэгтийн хураамж 184.2 мянган төгрөг, татварын орлого 5550.0 мянган төгрөгийг тус тус улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүллээ.

Тайлант хугацаанд тогтоосон хугацаанд бүртгүүлээгүй үйлдэлд хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг явуулж 20 иргэнд 400.0 мянган төгрөгийн торгууль ногдуулж, иргэний бүртгэлийн чиглэлээр 4, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 4, хуулийн этгээдийн чиглэлээр 2, нийт 10 дүгнэлт гаргаж, зөрчлийг арилгууллаа

Шүүхийн шинжилгээний алба: Зам тээврийн 3, хулгайн 1, хүн амины 3, бусад дуудлагад 1 удаа ажиллаж, мөр бусад ул мөрийг эд мөрийн баримтаар бэхжүүлэн авч ажиллалаа. Мөн хүний биед 10, задлан шинжилгээний 3, химийн шинжилгээний 6 нийт эрх бүхий этгээдийн 19 тогтоолыг бүртгэн авч гэмтлийн зэрэг тогтоох тухай 10 дүгнэлт гаргаж эрх бүхий албан тушаалтанд хүргүүллээ.

ГУРАВ. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮ, ХУДАЛДАН АВАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

Тайлант хугацаанд сум, байгууллагуудад 5915.4 сая төгрөгийн дэмжлэг, санхүүжилтийг бүрэн олгосноор 5243.3 сая төгрөгийн зарлагын гүйцэтгэл гарч, орон нутгийн төсөвт 626.6 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 672.2 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 107.3 хувиар, улсын төвлөрсөн төсөвт 117.7 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 142.8 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 121.3 хувиар тус тус биелүүллээ.

Мөн Сангийн сайдын аймгийн Засаг даргатай байгуулсан 2020 оны гэрээний биелэлт, Нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагчийн 2020 оны тайлан, Төрийн сангийн дотоод хяналтын 2020 оны тайлан, Санхүүгийн зохицуулах хорооны орон нутаг дахь төлөөлөгчийн 2020 оны ажлын тайланг тус тус холбогдох байгууллагуудад хугацаанд нь хүргүүллээ.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны төлөвлөгөөнд 133 ажил тусгагдаж, тайланг нь 2021 оны 01 сарын 15-ны дотор холбогдох яаманд нь хүргүүллээ.

2021 оны 01 сарын 26-ны АЗ гэрчилгээ олгох сургалтыг зохион байгуулж, 106 иргэн хамрагдан, 60 хүн шалгалтад тэнцэж, үнэлгээний хороонд ажиллах эрхтэй боллоо.

Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөнд 13 ажил тусгагдсан бөгөөд төлөвлөгөөг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn/ болон шилэн дансны цахим системд байршууллаа.

Тендерийн зар, дуудлага худалдааны зарыг өдөр тутмын сонинд байршуулах ажлын хүрээнд “Өдрийн сонин”-д нийтлүүлэхээр гэрээ байгууллаа.

Тайлант хугацаанд 9 ажлын тендерийг зарлаж, үнэлгээний хороо байгуулагдаж ажиллаж байна.

Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх Цагдаагийн газарт бичиг хэргийн материал нийлүүлэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт “Дижитал сервес” ХХК-ныг сонгон, захиалагчтай гэрээ байгуулах зөвлөмж хүргүүллээ.

Чех улсын Прага хотын буцалтгүй тусламжаар Говийн их дархан газрын “Б” хэсгийн хамгаалалтын захиргаанд байгаль хамгаалагчийн тохижуулсан контейнер, зөөврийн сууц авах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт 2 компани оролцсон боловч шаардлага хангахгүй үндэслэлээр захиалагчид дахин зарлах зөвлөмж хүргүүллээ.

Өмчийн асуудлаар: Аймгийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн нийт 8 асуудлыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралд өргөн мэдүүлж, шийдвэрлүүллээ.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 749 дугаар тогтоолоор аймгийн Усан бассейний барилга, байгууламжийг орон нутгийн өмчид бүртгэж авах шийдвэрийн хэрэгжилтийг хангуулан, Биеийн тамир спортын газрын 2020 оны санхүүгийн тайлан балансад бүртгүүллээ.

ДӨРӨВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР

Мал аж ахуйн чиглэлээр: Дэлхийн банкны санхүүжилтээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны хэрэгжүүлж буй “Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх” төсөл Говь-Алтай аймгийн Бигэр, Бугат, Дэлгэр, Тонхил, Төгрөг, Халиун, Чандмань, Цогт, Цээл, Эрдэнэ сумдын 4.2 мянган малчин өрхөд 1.1 тэрбум төгрөгийн хүчит тэжээлийн тусламж үзүүлэхээр шийдвэрлэж, эхний ээлжийн 330 тн тэжээлийг хүлээн авч сумдад хүлээлгэн өгөх ажлыг зохион байгууллаа.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас Бигэр, Бугат, Тонхил, Төгрөг, Халиун, Цээл, Чандмань, Дэлгэр сумдын зорилтот бүлгийн 160 малчин өрхөд тусламжийн тэжээл болон бусад холбогдох бараа бүтээгдэхүүнийг хүргүүллээ.

Улсын хошой аваргад 4 малчны, улсын аварга саальчинд 1 малчны, улсын аварга тариаланчид 2 тариаланчийн, улсын аварга малчинд 20 малчны, Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн “Алтан төлийн эзэн” шагналд 1 малчны материалыг тус тус хүлээн авч, дүгнэн, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, материалыг Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүллээ.

Аймгийн аварга малчин шалгаруулах журмыг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, 2021 оны А/18 дугаар захирамжаар шинэчлэн батлууллаа.

Аймгийн Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн А/35 дугаар захирамжаар аймгийн аварга малчин 85, аварга тэмээчин 3, аварга үхэрчин 1, аварга саальчин 1, аварга тариаланч 3, аварга хадланч 1, нийт 94 аварга шалгарлаа.

Аймгийн хэмжээнд 18 сумын давхардсан тоогоор 4332 малчны арьс, ширний урамшууллын падаан болон бусад материалыг хуулийн хугацаанд хүлээн авч урамшууллын анхан шатны программд оруулж, анхан шатны падааныг тулгах ажил хийгдэж байна.

Отроор яваа малчин өрхийн судалгааг гаргаж, өөр аймгийн нутагт 10 сумын 123 өрхийн 59.6 мянган толгой мал, өөрийн аймгийн бусад сумын нутагт 13 сумын 666 өрхийн 331.3 мянган толгой мал отроор өвөлжиж байна.

Аймгийн хэмжээнд том малын зүй бус хорогдлын мэдээг сумдаас авч нэгтгэн Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Малын генетик нөөцийн хэлтэст хүргүүлж байгаа бөгөөд 18.5 мянган толгой мал зүй бусаар хорогдсон байна.

Хүнс, газар тариалангийн чиглэлээр: Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Газар тариалан, жимс, жимсгэнэ” хөтөлбөрийн ТЭЗҮ боловсруулах ажлын даалгавар боловсруулж, календарьчилсан төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Сум хөгжүүлэх сангийн 2020 оны жилийн эцсийн байдлаар 128 иргэн, аж ахуйн нэгжид 768.4 сая төгрөгийн зээлийг олгосон.

Тус аймаг нь нийт 1202.6 тн мах бэлтгэсний 52.0 тн мах нөөцөд байна.

Мал эмнэлгийн чиглэлээр: Аймгийн хэмжээнд ургамал болон тэжээлийн хордлого, хөлний бэртэл, гэмтэл, дотрын халдварт хордлого, цусан халдвар зэрэг халдварт өвчнүүд элбэг байгаатай холбогдуулан Байгаль, зэрлэг амьтдыг хамгаалах нийгэмлэгийн санхүүжилтээр Бөхөнгийн хамгаалагч, байгаль хамгаалагч, малын эмч нарын хамтарсан бүрэлдэхүүн 2021 оны 1 дүгээр сарын 22-ны өдрөөс 24-ний өдрүүдэд Төгрөг, Шарга, Дарив сумдын 15 малчин өрхөөс асуумж, судалгаа авч ажиллалаа. Судалгааны дүнг нэгтгэн малын өвчний шинж тэмдэг, халдваргүйтлийн талаарх мэдээ мэдээллийг малчдад хүргэлээ.

Есөнбулаг сумд үйл ажиллагаа явуулж байгаа “Кристал”, “Андууд” ресторан, “Зочин”, “Ажай ээж” хоолны газар, “Тэгш-Алтай” цайны газрын 950 кг мах, 1 тн сүү, 300 ширхэг өндөгний дээжид мал эмнэлгийн ариун цэврийн магадлан шинжилгээ хийж гэрчилгээ олголоо.

ТАВ. БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТ, ДЭД БҮТЦИЙН ЧИГЛЭЛЭЭР

Захиргаа удирдлагын чиглэлээр: Улсын газар зохион байгуулалтын болон сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөний 2020 оны биелэлт, иргэнд эзэмшиж байгаа газрыг өмчлүүлсэн талаарх мэдээллийг газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газарт тус тус цахимаар хүргүүллээ.

Газрын харилцааны чиглэлээр: Газрын нэгдмэл сангийн тайлан мэдээ нэгтгэх ажлын хүрээнд газрын дуудлага худалдаа, үнийн мэдээний тайланг 18 сумаас нэгтгэн газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын холбогдох мэргэжилтэнд Газрын цахим биржийн систем /www.mle.mn/-ээр хүргүүллээ.

Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газраас 01 дүгээр сарын 04-ний өдөр зохион байгуулсан цахим хуралд аймгийн газрын төлбөр, татвар үнэлгээний асуудал хариуцсан мэргэжилтэн, "Монголын унаган байгалийн хүлцэл, тогтворжилтыг хангах нь "ENSURE" төслөөс зохион байгуулж буй "Бэлчээрийн доройтлыг бууруулах арга зам" сэдэвт цахим сургалтад суурь судалгаа, мониторинг хариуцсан мэргэжилтэн нар тус тус хамрагдаж, мэдлэг чадвараа дээшлүүллээ.

Газрын төлбөрийн системээс тайлан гаргах, засварлах чиглэлээр 18 сумын газрын даамалд 2020 оны 01 сарын 05-ны өдөр цахим хурал хийж, 15 чиглэлийн тайлан мэдээ системээс татах бэлтгэл ажлыг хангах 5 арга хэмжээг видео хичээл хэлбэрээр хүргүүллээ.

Цээл сумын 2021 онд баригдах шинэ сургууль, спорт заал, 120 айлын жишиг орон сууцны хороолол барих газрын хэмжээ байршлыг газар дээр хэмжилт хийж ерөнхий төлөвлөгөөний дагуу тогтоолоо.

Аймгийн Газрын нэгдмэл сангийн шинэчилсэн тооллогын ажилд 549 газрын байршилд ашиглалтын зориулалтаар тодруулалт хийлээ.

Засгийн газрын 2019 оны 476 дугаар тогтоолоор батлагдсан “Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян”-ыг зарласантай холбогдуулан аймаг, сумын хэмжээнд атаршиж орхигдсон, ашиглалтгүй болон тариалангийн газрын судалгааг 18 сумаас авч нэгтгэн газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газарт хүргүүллээ.

Барилга угсралтын чиглэлээр: Хот байгуулалтын кадастрын нэгдсэн мэдээллийн сангийн 4-р улирлын тайланг гарган газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газарт хүргүүллээ.

Орон нутгийн хөгжлийн сангийн 3.4 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 17 сумд хэрэгжүүлэх “Сумын шинэчлэл-хөдөөгийн хөгжил” төсөл арга хэмжээний хүрээнд 8 блок 120 айлын орон сууц барих газрын байршлыг тогтоож, инженер геологийн судалгаа хийх, 15 айлын орон сууцны барилгын зураг төсөв боловсруулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, ажлыг эхлүүлээд байна.

Эрчим хүчний зохицуулах хороонд Есөнбулаг сумын хэмжээнд байгаа халаалтын зуухтай барилгуудын судалгааг гаргаж дэвсгэр зургийн хамт цахимаар хүргүүллээ.

Аймгийн ерөнхий архитекторын 2020 оны тайланг 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 2/19 дугаар бүхий албан бичгээр болон цахимаар Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт хүргүүллээ.

Барилгын хөгжлийн төвийн 2021 оны 1/30 дугаар албан бичгийн дагуу Сумдын дэд бүтцийн мэдээллийг гарган osnaax@gmail.com цахим хаягаар хүргүүллээ.

“150 мянган айл-орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 2020 оны биелэлтийг гарган Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүллээ.

Барилга, хот байгуулалтын яамны 2021 оны 01 сарын 11-ны өдрийн 1/86 дугаар аймгийн дэд бүтцийн мэдээлэл ирүүлэх тухай албан бичгийн дагуу 2020 онд тус аймагт хэрэгжсэн бүтээн байгуулалт, 2021-2030 онд хэрэгжүүлэх инженерийн шугам сүлжээний төсвийн төсөөллийг гарган Барилга, хот байгуулалтын яамны bat-erdene@mcud.gov.mn цахимаар хаягаар хүргүүллээ.

2020 онд ашиглалтад орсон орон сууцны мэдээллийг статистикийн хорооноос гаргасан шинэчлэгдсэн маягтын дагуу гарган Барилгын хөгжлийн төвд хүргүүллээ.

“Барилгын салбарын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан”-ийн цахим системийн шинэчлэлт, хөгжүүлэлтийн ажил хийгдэж байгаатай холбоотой барилгын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагуудын 2020 оны жилийн эцсийн тайлан мэдээ ирүүлэх тухай ГХБХБГ-ын 2021 оны 01 сарын 25-ны өдрийн 45 дугаар албан бичгийг аймагт үйл ажиллагаа явуулж буй барилга угсралтын компаниудад хүргүүллээ.

Нийтийн аж ахуйн талаар: “Ундарга-алтай” ААТҮГ нь 5 гүний худаг, 1 нөөцийн худагтайгаар үйл ажиллагаа явуулж Алтай хотын иргэддээ 58934 м³ ус олзворлон түгээлээ.

2-р өргөлтийн насос станц: 2-р өргөлтийн насос станц 1 дүгээр сард 2 насос 1 нөөцийн насостойгоор үйл ажиллагаагаа явуулж нийт 53689.4 м³ усыг даралтат усан санруу шахлаа. Насос станцын хлоржуулах төхөөрөмжөөр 3 удаагийн хлорыг 3.6 кг гипохлороор цэвэр усанд тавьж ажиллажээ.

Цэвэрлэх байгууламж нь 01 сард 53899.4 м³ бохир усыг өөрийн картандаа хүлээн авч цэвэршүүлсэн бөгөөд 6.3 м³ усанд уусаагүй хольц буюу овор хэмжээ ихтэй хог хаягдлыг татан зайлуулж хогийн талбайд хаялаа.

2021 оны 1 дүгээр сард нийт 55 байгууллагад 23.0 гаруй сая төгрөгийн төлөвлөгөөтэйгээс Засгийн газраас усны үнийн хөнгөлөлт үзүүлсэнтэй холбогдуулан аж ахуй нэгж байгууллагын орлого 20.0 сая, орон сууцны орлого 1.4 сая, нийт 21.4 төгрөгийн орлого орлоо.

Эрчим

хүчний

чиглэлээр:

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн Цогт-Баянтоорой чиглэлийн 15кВ-ын ЦДАШ ашиглалтад орж, Баянтоорой тосгон төвийн бүсийн эрчим хүчний системд холбогдон 150кВт нарны цахилгаан станц зэрэгцээ ажиллагаанд орж, хэрэглэгчдийн цахилгаан эрчим хүчний найдвартай байдал хангагдаж байна.

Горим ажиллагааны талаар: Тайлант хугацаанд их ачаалал 21.4 МВт, бага ачаалал 11.4 МВт хүрсэн бөгөөд

Төвийн бүсийн Нэгдсэн систем 16.4 МВт, Баруун бүсийн Эрчим хүчний систем 0.6 МВт, Тайширын УЦС 2.4 МВт, Есөнбулаг сумын ДиЦС 1.4 МВт, Тосонцэнгэлийн УЦС 0.08 МВт чадалтай тус тус ажиллаж байна. Хоногийн нийт хэрэглээ 389.4 мян.кВт.ц. Нийт хэрэглээний 85%-ийг импортын ЦЭХ, 15%-ийг дотоодын эх үүсвэрээр хангаж байна.

Тайширын УЦС хоногт дунджаар 49.0 мян.кВт.ц, Есанбулагийн ДиЦС хоногт 5.3 мян.кВт.ц, Тосонцэнгэлийн УЦС 0.2 мян.кВт.ц ЦЭХ-ийг тус тус үйлдвэрлэж байна.

Төвийн бүсийн нэгдсэн системээс хоногт дунджаар 318.1 мян.кВт.ц, Баруун бүсийн эрчим хүчний системээс 15.7 мян.кВт.ц ЦЭХ-ийг импортлон авч байна.

Техник зохион байгуулалтын талаар: Баянтоорой-Ёлтон-Бигэр-Чандмань чиглэлийн ЦДАШ-ын 1-р шатны үзлэг шалгалтыг хийж, илэрсэн зөрчлийг арилган ажиллалаа. Цагаан-Олом 35/6 кВ-ын дэд станцын гүйдлийн трансформаторыг шинээр солих ажил хийгдсэн.

2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр Мөрөн-Тэлмэн 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамд гэмтэл устгах ажлыг “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-аас хийгдэхтэй холбоотойгоор аймгийн хэмжээнд хэсэгчилсэн цахилгаан эрчим хүчний хязгаарлалт хийгдсэн.

Тайшир УЦС нь 2021 оны 01 дүгээр сарын 01-нээс 2021 оны 01 дүгээр сарын 31-н хүртэл өвлийн их ачааллын горимоор “Төвийн бүсийн Эрчим хүчний систем”-тэй зэрэгцээ ажиллалаа.

2021 оны 01 дүгээр сарын горим хүснэгтээр харуулав:

Тайшир УЦС	Өдөр	I/01-I/31
	Цаг	24
Нэг агрегатын горимоор /МВт/		2.0
Үйлдвэрлэлт /м.кВт.цаг/		48.0
Нийт үйлдвэрлэлт /м.кВт.цаг/		1488.0

Нийт 1.509.600 кВт.ц ЦЭХ үйлдвэрлэснээс дотоод хэрэгцээндээ 5.26 хувийг хэрэглэж, 1.15 хувийг дэд станцад алдагдаж, 93.59 хувийг нь Алтай 35кВ-ын ЦДАШ-аар болон Улиастай 35 кВ-ын ЦДАШ-аар түгээлээ. Тайлант хугацаанд системээс баталсан горим ажиллагааг мөрдөн ажиллалаа.

“Авто тээврийн төв” Техникийн хяналтын үзлэг:

2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрөөс 2021 оны 01 дүгээр сарын 31-ний өдрүүдэд техникийн хяналтын үзлэгт суудлын автомашин 161, ачааны автомашин 41, автобус 2, чиргүүл 2, мотоцикл 18, нийт 224 тээврийн хэрэгсэл хамрагдаж, 93 тээврийн хэрэгсэл тэнцээгүй болно.

Халаалтын чиглэлээр: 2021 оны 01 дүгээр сарын 06, 07-ны өдрүүдэд цахилгаан тасарсны улмаас нэгдсэн халаалтын зуухнуудад гэмтэл гарч, 3кВ-90кВ-ын

нийт 12 хөдөлгүүр доголдсоныг Улаанбаатар хотоос мэргэжлийн засварчин ирүүлж, засварлан бүрэн ажиллагаанд орууллаа.

“Алтай” нисэх буудал: 2021.01.20-ны шөнийн нислэгээр УБ-аас 93 зорчигч ирж, Алтайгаас 72 зорчигч явсан.“Алтайн Хүдэр” ХХК-ийн 2 удаагийн захиалгат нислэгийн зорчигч үйлчилгээнд аймгийн МХГ-ын байцаагч нартай хамтран хяналт тавьж ажиллалаа.

“Мэдээлэл Холбооны Сүлжээ” ТӨХК: Сумдын техник тоног төхөөрөмжийн ерөөний температурт хяналт тавьж ажиллалаа. Тайлант сард халаалтын төхөөрөмж ажиллаж байгаа бөгөөд галын аюулгүй байдлыг ханган ажиллах талаар зааварчилгаа өглөө.

Тонхил, Төгрөг сумдад Төрийн банкны тооцооны төвийн шинэ барилга ашиглалтад орсонтой холбогдуулан шилэн кабелийн сүлжээнд холболоо.

Төгрөгсумын Мааньт багийн үндсэн сүлжээний агаарын шилэн кабель гадны нөлөөний улмаас гэмтсэнийг засварлан хэвийн үйл ажиллагаанд орууллаа.

Замын чиглэлээр: Автозам, замын байгууламжийн ашиглалтын байдлын төлөвлөгөөт үзлэг, графикийн дагуу Алтай-Бургастай чиглэлийн Авто замын байгууламжийн ашиглалтын байдлын төлөвлөгөөт үзлэг, Алтай-Баянхонгор чиглэлийн Авто замын байгууламжийн зорчих хэсэг дээр тогтсон 300 мм цас, цасан хунгарыг автогрейдэрээр цэвэрлэж зорчих хэсэг дээр хальтиргааны эсрэг элс, элс давсны хольцыг цацах, Алтай-Улиастай чиглэлийн авто замын байгууламжийн зорчих хэсэг дээр тогтсон цас, цасан хунгарыг автогрейдэрээр хусах, Алтай-Ховд чиглэлийн авто замын байгууламжийн зорчих хэсэг дээрх 300 мм хүртэлх зузаантай цасан хунгарыг автогрейдэрээр хусаж, зорчих хэсэг дээр хальтиргааны эсрэг элс, элс давсны

хольц цацах ажлыг тус тус хийж гүйцэтгэсэн ба нийт 54.9 сая төгрөг зарцууллаа.

ЗУРГАА. НИЙГМИЙН САЛБАР:

Эрүүл мэндийн чиглэлээр: Ковид-19-тэй холбоотой цаг үеийн шаардлагаар авдаг мэдээллийг 1 дүгээр сард 22 удаа хянан баталгаажуулж, нэгтгэн Эрүүл мэндийн хөгжлийн төвд илгээлээ.

НҮБ-ын ХС-ийн 69.5 сая төгрөгийн санхүүжилтээр Агаарын бохирдлын эх хүүхдийн эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг бууруулах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах зорилгоор хийгдсэн тохижилт, тоног төхөөрөмжийг хүлээн авч,ашиглалтад орууллаа.

Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/04, Эрүүл мэндийн газрын даргын 2021 оны А/03 дугаар тушаалаар Эрүүл мэндийн байгууллагуудыг бүх нийтийн бэлэн байдалд шилжүүлэн ажиллалаа.

Олон нийтийн эрүүл мэндийн ажилтны хөтөлбөр хэрэгжүүлэх цахим сургалтад Эрүүл мэндийн газрын 4 мэргэжилтэн оролцлоо. “Эрүүл мэндийн байгууллага дахь

ковид-19 халдварын сэргийлэлт, хяналт” сэдэвт цахим сургалтад 16 байгууллагын 121 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдлаа.

“Эрүүл мэндийн байгууллага дахь ковид-19 халдварын сэргийлэлт, хяналт” сэдэвт цахим сургалтад 16 байгууллагын 121 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдлаа.

Аймгийн онцгой комиссын хурлаар ковидын халдварын үед уул уурхайн ээлж солилцоонд мөрдөж байгаа дүрэм журмууд, оношилгоо шинжилгээний түр цэг ажиллуулах зардлыг гаргах, гэрийн хяналтыг сайжруулах 3 асуудлаар мэдээлэл хийж, 2064.0 төгрөгийг шийдвэрлүүлээ.

Эрүүл мэндийн шуурхай штабын байр, Бууцагаан сумын постод эрүүл мэндийн ажилтнууд 24 цагаар жижүүрлэн ажиллаж 70484067 утсаар мэдээлэл авч, зөвлөгөө өгч байна.

Шарга сумын Эрүүл мэндийн төвд 4 хүний бүрэлдэхүүнтэй зөвлөн туслах баг ажиллаж, зөвлөмж хүргүүлэн, хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.

Аймгийн Нэгдсэн эмнэлэг, сумдын эмнэлгийн 2021 онд шаардагдах эмийг худалдан авах нээлттэй тендер 2021 оны 01 сарын 22-ны өдөр нээж, үнэлгээ хийж шалгарууллаа.

Бүх сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдээс шүдний кабинетэд ажиллах хүний нөөц, мобайл технологийн судалгаа авч Эрүүл мэндийн яаманд хүргүүллээ.

Геронтологийн үндэсний төвөөс настны эрүүл мэндийг дэмжих, хамгаалах ажлын хүрээнд Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг олон нийтийн оролцоонд түшиглэн өргөжүүлэх, тулгамдаж байгаа асуудлыг хэлэлцэх цахим уулзалтыг зохион байгуулж 41 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдан, мэдээлэл авлаа.

Ковид-19 цар тахлын бэлэн байдалтай холбоотой эрүүл мэндийн төвүүдэд мэргэжил арга зүйн зөвлөмж өгч ажиллалаа.

2021 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн байдлаар гэрийн ажиглалтад 5116, түргэвчилсэн оношлуурын шинжилгээнд 4573, PCR шинжилгээнд 538 иргэн хамрагдсан байна. Одоо гэрийн ажиглалтад 291, гэрийн ажиглалтаас 59 хүн гарсан байна.

Шарга сумын Эрүүл мэндийн төвд дэмжлэгт хяналт-зөвлөн туслах багаар ажилласаны үр дүнд анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд нийтдээ анхаарвал зохих асуудлын талаар 01-р сарын 25-ны өдөр зохион байгуулагдсан ZOOM хурлаар мэдээлэл хийлээ. Хуралд 13 байгууллагын 101 эмч, эмнэлгийн мэргэжилтэн оролцлоо.

Улаанбаатар хот дахь нутгийн зөвлөлөөс санаачилан Эрүүл мэндийн газар, аймгийн нэгдсэн эмнэлэгтэй хамтран отрын малчдад эрүүл мэндийн тусламж үзүүлэх, урьдчилан сэргийлэх үзлэгийг Дарив, Хөхморьт, Баян-Уул, Жаргалан сумдад зохион байгуулж орон нутгийн 150, отроор өвөлжиж байгаа 11 сумын 300, нийт 450 малчин өрхийн 770 малчин хамрагдан дотор, дүрс оношилгооны эмч нар давхардсан тоогоор 1457 хүнд үзлэг хийлээ. Тус үзлэгт мобайл технологийн төхөөрөмж ашиглан отрын малчны гэрт ЭХО-д харан, зүрхний бичлэг хийж, шинээр өвчлөл илэрсэн 46,

жирэмсний эрт хугацаанд илэрсэн 1 эх болон онош тодруулах, эмчийн хяналтад давтан үзүүлэх шаардлагатай 36, нийт 83 хүнийг лавлагаа шатлалын эмнэлэгт шилжүүллээ.

Аймгийн нэгдсэн эмнэлэгт 2021 оны 1 дүгээр сард 3298 ор хоногийг ашигласнаас хүнд өвчтөн 56 байсан ба нас баралтын тохиолдол гараагүй байна. Амбулаториар нийт 5803 үйлчлүүлэгч үзүүлснээс томуу, томуу төст өвчинтэй 15 тохиолдол бүртгэгдлээ. Хүүхдийн тасагт 339 ор хоногийг ашигласнаас 28 хүнд хүүхэд эмчлэгдлээ. Энэ хугацаанд нийт 90 эх эсэн мэнд амаржиж 90 хүүхдийг хүлээн авлаа. Нийт 88 мэс засал хийснээс мэс заслын тасагт 68, гэмтлийн тасагт 9, төрөх, эмэгтэйчүүдийн тасагт 11 байлаа. Түргэн тусламжийн 279 дуудлагад үйлчиллээ. Яаралтай тусламжийн тасагт 414 хүн өөрөө ирж үзүүлснээс 18 буюу 4.3% нь томуу, томуу төст өвчний тохиолдол байлаа. Алсын дуудлагын 9 тохиолдолд үйлчиллээ.

Миний нутаг телевиз, радио, сонинд тус бүр 9 удаагийн цаг үеийн мэдээлэл болон эрүүл мэндийн зөвлөгөө, мэдээлэл өгч, олон нийтэд хүргэлээ.

Боловсролын чиглэлээр: Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан “Төрөлжсөн болон гүнзгийрүүлсэн сургалттай сургуулийн тоог нэмэгдүүлж, Тайшир сумын сургуулийг түшиглэсэн “Вакумжуулсан сургалтыг нэвтрүүлнэ” гэсэн заалтын дагуу 2021 оны 01-р сарын 13-ны өдөр хэлэлцүүлэг зохион байгуулж, Тайшир сумын сургуулийн сургуулийн өнөөгийн нөхцөл байдал, цаашид гүнзгийрүүлсэн болон вакумжуулсан сургалт зохион байгуулах боломж бололцоо, шаардагдах хөрөнгө оруулалт, давуу болон сул талаа тодорхойлсон СВОТ шинжилгээг танилцууллаа.

Хэлэлцүүлгийн үр дүн: Тайшир сумын сургуульд ОУ-ын хөтөлбөр, арга зүйг нэвтрүүлэх, гүнзгийрүүлсэн сургалттай сургууль байгуулах саналыг дэмжиж цаашид хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гаргах, ажлын хэсэг байгуулах, хөрөнгө санхүүг шийдвэрлэх зэрэг ажлуудыг яаралтай хийж эхлүүлэхээр хэлэлцлээ.

Нийтийн номын сангийн захирал, Орон нутаг судлах музейн захирал, Алтай чуулгын даргын ажлын байрны тодорхойлолтыг Соёлын сайдын 2020 оны А/75 дугаар тушаалын хавсралтын дагуу шинэчлэн боловсруулж хүргүүллээ.

2021 оны 1 дүгээр сарын 11-нд Соёлын төвийн эрхлэгч, ажилтнуудтай цахим уулзалт зөвлөгөөнийг зохион байгуулж, чиглэл зөвлөгөө өглөө.

ЕБС-ийн сурагчид болон олон нийтэд гэрийн нөхцөлд дасгал хөдөлгөөнөөр хичээллэх чиглэлээр Тонхил сумын сургуулийн биеийн тамирын багшийн 8 дугаар ангийн мини волейболын, биеийн тамирын багш нарт олон улсын түвшинд хэрэглэж буй биеийн тамирын хэрэглэгдэхүүн ашиглах заах арга зүйд чиглэсэн 2 төрлийн цахим бичлэг, бага боловсролын Монгол хэлний сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх зөвлөмж, суралцахуйн удирдамж зэрэг гарын авлагыг ашиглан багш нарын хэрэгцээнд нийцэх видео сургалтыг тус тус боловсруулан олон нийтэд түгээлээ.

НҮБ-ын “Хүүхдийн сан”-гийн санхүүжилтээр Хөхморьт сумын гэр цэцэрлэгт нийлүүлэх сургалтын тавиур, тоглоом, ширээ сандлыг нийлүүллээ.

Боловсрол, шинжлэх ухааны яам, Боловсролын хүрээлэн, Багшийн мэргэжил дээшлүүлэх институтээс “Суралцагч бүрийн суралцахуйг дэмжихэд Боловсролын газрын оролцоо, мэргэжил арга зүйн дэмжлэг” сэдэвт онлайн хэлэлцүүлэг 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс 28-ны өдрүүдэд зохион байгуулагдаж, бүх судлагдахууны мэргэжилтнүүд болон зарим мэргэжлийн багш нарыг хамруулан мэдлэг чадвараа дээшлүүллээ.

БШУЯ-наас зохион байгуулсан СӨБ-ын мэргэжлийн багийн болон Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол, хөгжлийн талаарх онлайн хэлэлцүүлэгт тус тус оролцож, чиглэл авлаа.

БШУЯ-аас 2 дугаар улирлын хичээл эхлэхтэй холбоотой бэлтгэл ажлын хүрээнд хийх ажлын чиглэлээр цэцэрлэгийн эрхлэгч нарт цахимаар мэдээлэл өглөө.

Боловсролын байгууллагад гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын тухай хууль, стандарт норм, норматив, баримт бичиг, түүний хэрэгжилтийг хангуулах, сургууль, дотуур байрны орчны аюулгүй байдлыг сайжруулах, стандартыг хэрэгжүүлэх, аюулгүй байдлыг хангах зорилготой “Гамшгийн эрсдэлийг бууруулах, орчны аюулгүй байдлыг сайжруулахад шаардлагатай зарим техникийн дэмжлэг үзүүлэх” сэдэвт сургалтыг 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр танхимын болон онлайн хэлбэрээр зохион байгууллаа. Сургалтад сургуулийн удирдлага, дотуур байрын багш, галын аюулгүй байдал хариуцсан нийт 80 ажилтан оролцлоо. Сургууль тус бүрд 9 төрлийн 303000 төгрөгийн багаж хэрэгслийг НҮБ-ын Хүүхдийн сангийн хөрөнгө оруулалтаар хүлээлгэн өгч тодорхой хугацаанд хийх ажлын чиглэлийг хүргүүллээ.

01 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгуулагдсан эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар хүртээмжийг сайжруулах төслийн сургалтын хөтөлбөрийг сайжруулах тухай зөвлөлдөх семинарт хамрагдлаа.

Хүүхэд, гэр бүлийн чиглэлээр: Хамтарсан багийн 2020 оны тайланг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт хүргүүллээ.

“Гэр бүлд зөвлөгөө өгөх төв”-өөр хүүхэд 5, насанд хүрэгч 7, нийт 12 хүн үйлчлүүлж, сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээг үзүүллээ.

Залуучуудын хөгжлийн төвийн 2020 оны үйл ажиллагааны видео тайлан бэлтгэж залуучуудын хөгжлийн төвийн үйл ажиллагааг олон нийтэд түгээн ажиллалаа.

Гэр бүлийн боловсрол олгох, хүүхэд хүмүүжлийн эерэг арга зүйг түгээн дэлгэрүүлэх, сэтгэл зүйн эрүүл мэндийн чиглэлээр бэлтгэж хүргэсэн постер бүхий 8 удаагийн зөвлөгөө, мэдээллийг 3692 хүнд хүргэж, 34 удаа

бусадтай хуваалцсан, 4 удаагийн видеог 490 хүнд хүргэж, 7 удаа бусадтай хуваалцсан үзүүлэлттэй байна.

“Хувь хүний манлайлал”, “Өөрийгөө судлах” сэдэвт цахим цуврал хичээлийг Залуучуудын хөгжлийн төвийн пэйж хуудаст тус тус байршуулан 350 иргэнд хүргэлээ.

Даатгал: Нийгмийн даатгалын сангаас үйлчилгээ авагч иргэдийн тэтгэврийг 01 дүгээр сарын 01-нд багтаан олгож, олгогдоогүй тэтгэвэр тэтгэмжийн өглөггүй ажиллалаа.

Аймгийн хэмжээнд өндөр насны тэтгэвэр авагч 9343 иргэнд 3166.7 сая төгрөгийг олголоо. Шинээр тэтгэвэр тогтоолгохоор хүсэлт гаргасан өндөр настан 20, тахир дутуу 6, тэжээгчээ алдсаны тэтгэвэр 2, нийт 28 даатгуулагчийн тэтгэврийн баримт материалыг хүлээн авч, хуулийн хүрээнд шийдвэрлэлээ.

Тэтгэмжийн даатгалын сангаас жирэмсэн амаржсаны тэтгэмж 11 хүнд 17.6 сая, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж 40 хүнд 5.7 сая, оршуулгын тэтгэмж 8 хүнд 8.0 сая, ажилгүйдэлийн тэтгэмж 27 хүнд 16.7 сая төгрөгийг тус тус олголоо.

Сайн дурын даатгалд нийт 195 хүн хамрагдсанаас 150 хүн ажилгүй, 0-3 насны хүүхдээ асарч буй 45 эхийг хамрууллаа.

Эрүүл мэндийн даатгалд 737 иргэн хамруулж 41.5 сая төгрөг ЭМД-ын санд хуримтлагдлаа.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хурлаар 240 хүн орж, үүнээс шинээр-34 хүн хөдөлмөрийн чадвар алдалт тогтоолгож, 194 хүний групп сунгагдлаа.

Нийгмийн даатгалын шимтгэл төлөлттэй холбоотой лавлагааг 40 хүнд гаргаж өглөө.

Хөдөлмөр, халамж: Тайлант хугацаанд 10 иргэн ажил хайгчаар бүртгүүлж, 4 иргэн ажлаасаа чөлөөлөгдөж, ажилгүйдлийн тэтгэмжийн тодорхойлолт авлаа.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжин сангаас олгосон санхүүгийн дэмжлэгийн 184 хүний 73720.7 мянган төгрөгийг эргэн төлүүлж, тус санд төвлөрүүллээ.

Нийт 6 иргэнийг байнгын ажлын байранд зуучлан ажилд орууллаа.

Нийгмийн халамжийн сангаас ихэр хүүхэдтэй 2 иргэнд 4.0 сая төгрөг, жирэмсэн эхийн тэтгэмж 541 эхэд 19.9 сая төгрөг, 0-3 насны хүүхдээ асарсны тэтгэмж 2750 иргэнд 135.2 сая төгрөг, өрх толгойлсон 3 иргэнд 1.1 сая төгрөгний санхүүжилт тус тус олгосон ба халамжийн тэтгэвэр 7 иргэнд 1.6 сая төгрөг, Нөхцөлт мөнгөн тэтгэмж 156 иргэнд 11,0 сая төгрөг, хүүхэд асарсны тэтгэмж 73 иргэнд 2.5 сая төгрөг, жирэмсэн эхэд олгох тэтгэмж 43 иргэнд 0.9 сая төгрөг, амьжиргаа дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж 56 иргэнд 4.0 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт, тусламж 36 иргэнд 5.5 сая төгрөг, ахмад настны хөнгөлөлт тусламж 55 иргэнд 13.6 сая төгрөгийн нийгмийн халамжийн үйлчилгээг тус тус үзүүллээ.

Шинэ төрсөн 37 хүүхдийг өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэж, нас барсан 760 иргэнийг хаслаа.

ДОЛОО. БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЧИГЛЭЛЭЭР

Нэн ховор, ховор амьтдад биотехникийн арга хэмжээ авах ажлыг өвөлжилт хүндэрсэн Хантайширын нуруунд нутагшуулж байгаа бугын илийд зориулж 100 боодол өвс, 200 кг хужир, Шарга, Халиун, Бигэр, Тайшир, Чандмань, Дэлгэр сумдын болон сумын Олонбулаг баг нутагт байрших янгир ямаа, хар сүүлт, аргальд нийт 450 боодол өвс ачууллаа.

Биотехникийн арга хэмжээ авах ажлыг сумдын байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч зохион байгуулан ажиллаж байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас нийт 5.0 сая төгрөг зарцууллаа.

Аймгийн ИТХ-ын Тургүүлэгчдийн 2021 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн хуралдаанаар Сутай хайрхан уулын менежментийн төлөвлөгөөг хэлэлцүүлэн батлууллаа.

Сутай хайрхан уулын байгаль, экологийн тэнцвэртэй байдлыг хадгалах, түүх соёлын дурсгалт газруудад түшиглэн аялал жуулчлал хөгжүүлэх, биологийн олон янз байдлын амьдрах орчныг хэвээр хадгалан үлдээх зорилгоор тус аймгийн Тонхил, Дарви, Ховд аймгийн Дарви, Цэцэг сумын нутгийг дамнан орших газар нутгийг УИХ-ын 2019 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 41-р тогтоолоор байгалийн нөөц газрын ангиллаар хамгаалалтад авлаа.

Сутай хайрхан уулын менежментийн төлөвлөгөөг Ховд аймгийн Байгаь орчин, аялал жуулчлалын газартай хамтран боловсрууллаа.

Тус аймгийн Цогт, Эрдэнэ, Алтай, Бугат, Тонхил сумдад хэрэгжиж буй “Биологийн Олон Янз Байдлыг Хамгаалах, Уур Амьсгалын Өөрчлөлтөд Дасан Зохицох” төслийн дэд зөвлөх тус аймагт ажиллаж төслийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, 2021 онд хийгдэх ажлын төлөвлөгөөг танилцуулж хамтран ажиллах чиглэлээр зөвлөгөө өгч ажиллалаа.

Тайлант хугацаанд төв цэвэрлэх байгууламжийн орох, гарахын цооногоос бохир усны дээж авч химийн шинжилгээг хийлээ.

Геологи уул уурхайн салбарт: “Нөхөн сэргээлт 2024” арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулж 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсрууллаа.

2021 онд уул уурхайн олборлолтод өртсөн 22.57 га, дэд бүтцийн 4.35 га, хууль бусаар ашигт малтмал олборлолтод өртсөн 7.9 га талбайд нөхөн сэргээлтийг хийлгэх зорилт тавин ажиллаж байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах тайлагнах журам”-ын дагуу аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг “Гоби коулд энд энерги ХХК”-ийн Зээгтийн нүүрсний уурхай, “Болдгянтболд” ХХК-ний Зүүн сайрын алтны шороон ордын уурхай болон “Майн бласт” ХХК-ийн тэсрэх материалын агуулах, цогцолборын 2020 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэн хангалттай гэсэн дүгнэлт өглөө.

Харин “Алтайн хүдэр” ХХК-ийн Таяннуурын төмрийн хүдэр, гантигжсан шохойн чулууны ордын уурхайн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хянаж шалган хангалтгүй дүгнэгдэж, тайлангийн иж бүрдэл дутуу “Цогц эрин транс”

ХХК-ийн Бөөрөгийн алтны шороон ордын уурхайн төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэх ажил хүлээгдэж байна.

НАЙМ. ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр: Аймгийн Засаг даргын 2021 оны А/03 тоот захирамжаар хэвийн горимд шилжин ажиллаж байгаа спорт заалууд, фитнес, спиннинг, теннисний клубууд, газрын тосны бүтээгдэхүүн, түлшний хангамж, түгээлт, тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжүүд болон үсчин гоо сайхны газруудад үйл ажиллагаанд ковид 19 цар тахалтай холбоотойгоор гарсан журам, зөвлөмжүүдийн хэрэгжилтийг тус тус шалгаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

Албан хаагчдад гар угаах, ариутгалын бодисоор гар халдваргүйжүүлэх зөв дадал сургах сургалтыг ажлын байранд нь сургаж дадлагажуулах ажлыг зохион байгууллаа.

Мөн аймгийн Засаг даргын 2020 оны 12 дугаар сарын 15-ний өдрийн А/676 дугаар захирамжийн дагуу зах, үсчин, худалдаа үйлчилгээний төвүүдийн цагийн хуваарь, өндөржүүлсэн бэлэн байдлын үед худалдаа үйлчилгээний газруудын мөрдөж ажиллах зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилган ажиллалаа.

Улсын хэмжээнд бүх нийтийн бэлэн байдлын зэргээс өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан гэрийн ажиглалтад байгаа иргэдийн үйл ажиллагаанд тус газраас хяналт шалгалтыг тогтмол зохион байгуулж, илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүр нь арилгаж, гэрийн ажиглалтад байгаа иргэдэд холбогдох заавар зөвлөмжийг өгч ажиллалаа.

Хүнсний үйлдвэр, худалдааны үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгжид төлөвлөгөөт бус шалгалт хийгдэж байна.

Нэгдсэн лаборатори: Эмнэлгийн ариун материалын багажинд 15 сорьц 15 үзүүлэлт, хүнсний бүтээгдэхүүний 10 сорьц 58 үзүүлэлт, ундны усны 2 сорьц 17 үзүүлэлтээр хими, нян судлалын шинжилгээ хийж ажиллалаа. Үүнээс ундны уны 1 сорьц 2 үзүүлэлт, хүнсний бүтээгдэхүүний 1 сорьц 2 үзүүлэлтээр стандартын шаардлага хангаагүй. 100.0 мянган төгрөгийг бүрэн төвлөрүүллээ.

ЕС. СУМДАД ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН ОНЦЛОГ АЖИЛ:

Баян-Уул сум: 2020 оны худалдан авах ажиллагааны тайлан болон 2021 оны бараа ажил үйлчилгээ худалдан авах ерөнхий төлөвлөгөөг гарган батлуулж аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлэн Tender.gov.mn сайтад байршуулан Сангийн яамаар хянуулан батлуулж, цахим тендер зарлах ажлыг эхлүүлэн сумын ЗДТГ болон Хүн эмнэлгийн шатахууны худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороог байгуулан, тендерийн зар, урилгыг байршууллаа.

Эцэг эхчүүдийн хүсэлтийн дагуу 01 сарын 25-аас эхлэн 12 ангийн сурагчдад халдвар хамгааллын дэглэмийг баримтлан давтлага өгч эхэллээ.

Бигэр сум: Засгийн газраас олгосон буцалтгүй тусламжийн хүрээнд малчдад өвс тэжээл олгох ажлыг 01 дүгээр сарын 12-ны өдрөөс эхлүүлж 1 өрхөд 1,5 сав тэжээл, 1.5 боодол өвс олгож эхэллээ. Сумын Засаг даргын захирамжаар тус ажлыг зохион байгуулах шуурхай бүлэг байгуулан ажиллуулж байна.

Зэрлэг амьтдад биотехникийн арга хэмжээ авах ажлыг 5 удаа зохион байгуулж, 35 боодол өвсийг хар сүүлт зээрийн бэлчээрт тавилаа.

Тайлант хугацаанд 5 багийн иргэдийн Нийтийн Хурал хуралдаж багийн ИНХурлын болон Засаг дарга нарыг сонголоо.

Бугат сум: Сургуулийн зорилтот бүлгийн 17 сурагчид хүнсний дэмжлэг үзүүлж, хуваарилсан хүнсийг багийн Засаг даргаар нараар нь дамжуулан хөдөө байгаа өрхүүдэд хүргэлээ.

“Цахим орчинд соёл түгээе” аяны хүрээнд хуурын татлага мэндчилгээ, соёлын уран уншлага, “Уул говийн дуулал” концерт болон “Би чамд хайртай” жүжгийн фото зургийг тайлбартай, уран уншигчдын шүлгүүд, нийт 6 ажил үйлчилгээг олон нийтэд цахимаар сурталчилан ажиллалаа.

Жаргалан: Аймгийн эдийн засаг, нийгмийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд тусгагдсаны дагуу иргэдийг хямд өртөгтэй орон сууцаар хангах зорилгоор 120 айлын орон сууцны барилгын байршлыг тогтоож 6942 м² газрыг эзэмших гэрчилгээг олголоо.

Даралтат хөгжмийн дугуйлан хичээллүүлж нийт 7 хүүхэд, соёлын төвийн 2 ажилтан хамрагдаж, анхан шат нотыг зааж эхлээд байна.

Тайшир: Сумын ЗДТГ болон төсөвт байгууллагуудад ажлын байран дээр шинэ үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн талаар мэдлэг олгох сургалт зохион байгуулж, нийт 74 төрийн албан хаагч хамрагдлаа.

Төрийн албан хаагчдын мэдлэгийн түвшинг үнэлэхэд сургалтын өмнө 46%, сургалтын дараа 74%, сургалт зохион байгуулснаар төрийн албан хаагчдын мэдлэгийн түвшин 28% нэмэгдсэн байна.

Халиун: Засгийн газраас Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл”-ийн хүрээнд өвөлжилт хүндэрч байгаа аймгуудын малчин өрхөд малын тэжээл олгох ажлын хүрээнд 1150 уут тэжээл татан авч иргэдэд хүргэлээ.

Сумын ЗДТГ болон төсөвт байгууллагуудад ажлын байран дээр бөөгнөрөл үүсгэхгүйгээр шинэ үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн талаар мэдлэг олгох сургалт зохион байгуулж, 3 хэсэг болгон нийтдээ 30 гаруй төрийн албан хаагч хамрагдан мэдлэг чадвараа дээшлүүллээ.

Соёлын төвөөс монгол бичигт бүх нийтээрээ суралцах аяны хүрээнд Монгол улсын төрийн дууллыг монгол бичгээр бичих аяныг цахимаар уриалж 60 орчим иргэн хамрагдаад байна.

Отроор өвөлжиж буй малчин өрхүүдэд туслах зорилготойгоор “Хахир өвөл – Халуун сэтгэл” аяныг байгууллагынхаа багш, ажилчдын дунд зохион байгуулсан ба нийт 400 малын хошуувч, 80 дулаан бээлий цугларч, малчин айлуудад хүргэгдлээ.

Цогт: Татварын бааз суурийг нэмэгдүүлэхээр татварт хамрагддаггүй малчдын ашиг шимийн орлогоос 2460,0 төгрөгийн татвар төвлөрүүллээ.

“Сумдын шинэчлэл-Хөдөөгийн хөгжил төсөл”-ийн хүрээнд 120 айлын орон сууц барих газрын байршлыг тогтоон, газрын координат бүхий зураглалыг хийж, тэмдэгжүүллээ.

Улсын төсвийн хөрөнгөөр баригдах 1500.0 сая төгрөгийн өртөг бүхий 500 хүний суудалтай спорт заалны барилгын газрыг Сумын Засаг даргын захирамжаар эзэмшүүлж, барилгын Архитектур төлөвлөлтийн даалгавар боловсруулах албан бичгийг холбогдох газарт хүргүүллээ.

Цээл: Сумын ИТХ-ын тэргүүлэгчид, ЗДТГ-ын ажлын хэсгийн бүрэлдэхүүн 4 багийн 256 өрхийн 465 иргэнд Эрүүл мэнд, боловсрол, ХАА, Мал эмнэлийн үйлчилгээ, 2022 онд ОНХСангийн хөрөнгөөр хийгдэх ажлын санал, аймаг, сумын Засаг даргын 2020-2024 онд хөгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, Малчдыг орон сууцжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд малчдаас орон сууцанд хамрагдах саналыг нэгтгэх ажлыг зохион байгууллаа.

Шарга: Тус сум 2020 оны шилдгээ 9 номанициар шалгаруулж, шагналаа.

Тайлант хугацаанд сумын ИТХ, ЗДТГ-ын албан хаагчдын хандиваар “Дулаан гэр” сэтгэлийн аяныг өрнүүлж 15 өрхөд мод, нүүрсний дэмжлэг үзүүллээ.

Тайлант хугацаанд 10-12 дугаар ангийн сурагчдад онлайн давтлагыг эхлүүлж, нийт 20 сурагч хамрагдаж байна. 12-р ангийн сурагчдаас ЭЕШ өгөх хичээлүүдийн саналыг цахимаар авч, хэсэгчилсэн давтлагыг хуваарийн дагуу өгч эхэллээ.

Гэрийн ажиглалтад 9 иргэн байгаа бөгөөд өдөрт 1 удаа иргэнтэй холбогдож халууныг нь хэмжүүлж, мэдээ, зөвлөмж өгөн хяналт тавьж байна. COVID-19 халдварын түргэвчилсэн оношлуураар 34 хүнд шинжилгээ хийсэн байна. Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр иргэдэд 6 удаа мэдээлэл, сургалт сурталчилгаа хийж, цахимаар 16 удаагийн зөвлөмжийг байршуулан мэдээлэл хүргэн ажилласан байна.

Эрдэнэ сум: Тайлант хугацаанд “Хахир өвөл-Халуун сэтгэл” малчдад туслах аяныг зохион байгуулж, төрийн байгууллага, ААН, ард иргэд нэгдэн, эд зүйл, бараа материалыг малчдад хүргэлээ.

Төрийн албан хаагчид өрхийн угийн бичгээ хөтлөх удирдамжийг боловсруулж сумын Засаг даргаар батлуулан, цахимаар мэдээлэн эхний ээлжийн сургалтыг байгууллагын болон хүүхдийн цэцэрлэгийн албан хаагчдад зохион байгууллаа.

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

